

Түүх 5 : Сүүлчийн зоог

Библийн эшлэл
[Матай 26:26]

Тэднийг зооглох зуур Есүс талх аваад, ерөөсний дараа хуваан шавь нартаа өгөөд – Май, ид, энэ Миний бие гэлээ.

Израильд дээгүүр өнгөрөх баяр ойртож байлаа. Дээгүүр өнгөрөх баяр гэдэг нь Израиль ард түмэн Египетэд боол байх үед чөлөөлөгдөн эрх чөлөөтэй болсон тэр өдрийг дурсан санаж тэмдэглэдэг өдөр юм.

Израиль хүмүүст Дээгүүр өнгөрөх баяр нь маш том баярт өдөр учраас заавал тэмдэглэх ёстой баярын нэг юм.

Есүс, одоо газар дээр хийгдэх ажил нь дуусаж тэнгэрийн улс руу буцаж явах цаг нь болсоныг мэдэж байлаа.

Тэгээд дээгүүр өнгөрөх баярын урд орой нь дагалдагч нартайгаа хамтдаа нэгэн онцгой цагийг гаргах гэж бүгдийг нь цуглуулав.

Дагалдагч нар бүгд ширээнд сууцгаахад Есүс тэдний хөлийг угааж эхлэв. Дагалдагч нар нь ихэд гайхжээ.

Дагалдагч нар нь болохгүй гэсэн боловч Есүс хүн нэг бүрийн хөлийг цэвэрхэн болтол нь угааж өгөв.

Дагалдагч нар нь хөлөө угаалгахдаа ихэд санаа зовон яах аа ч мэдэхгүй байлаа.

Энэ үед Петрийн ээлж болов. Петр Есүст ингэж хэлэв.

Есүс ээ, Та юунд миний бохир хөлийг зарц шиг угаах гэнэ вэ? Ингэж болохгүй шүү дээ.

Есүс түүнд ингэж хариулав. “Би хөлийг чинь угааж байж чи Миний шавь болно.”

Петр, Есүсийн хэлсэнийг сонссоноос эхлүүлэн сэтгэлээ өөрчилж, Есүсээс “миний хөл байтугай гар, толгойг минь ч гэсэн угаагаад өгөөч” гэж хүсэв. Есүс 12 дагалдагч нарынхаа хөлийг угаасны дараа ширээнд суун үгээ хэлэв.

“Би та нарыг хөлийг угааж өгсөн шиг, та нар ч мөн бусдын хөлийг угааж өгөх сэтгэлтэй бай.

Би та нарт хэрхэн яаж хандсан шиг бусдад бас тэгж ханд.” Дагалдагч нар нь Есүсийн хэлсэн үгийг сэтгэлдээ гүн хадгалав.

Есүс талхыг өргөөд Бурханд талархан залбирсны дараа хуваан дагалдагч нартаа өгөв.

Мөн аягатай дарсыг аван залбирсны дараа дагалдагч нартаа өгөв. Хооллож дуусаад Есүс дагалдагч нартаа хэлэв.

“Та нар намайг одоо дагаж байгаа боловч, удалгүй намайг орхин зугтах болно.”

Есүс үргэлжлүүлэн ингэж айлдав. “Одоо Миний явах цаг болсон байна. Миний очих газарт та нар хараахан очих болоогүй.

Би тэнгэрийн улсад очоод та нарын орон байрыг бэлдэх бөгөөд хожим дахин буцан ирэх болно.”


Есүс дагалдагч нартайгаа дахин уулзахаа амлаад сүүлчийн оройн зоогийг хамтдаа өнгөрүүлэв.

Дагалдагч нартайгаа барьсан талх болон усан үзмийн дарсыг өнөөдрийг хүртэл дурсан санаж үйлдсээр байгаа билээ.


Үүнийг “Ариун зоогийн ёслол” гэж нэрлэдэг.

Ариун зоогийн ёслолоор дамжуулан бидний гэм нүглийн төлөө нас барсан Есүсийг дурсан санаж, биднийг аварсан Есүст талархсан сэтгэлээр оролцдог юм.





Бүтээлч байцгаая 2. Өөрийнхөө хөлийг маш гоёор зураарай.



- Дараах библийн эшлэлийг дагаж бичээд, цээжлээрэй. (Матай 26:26)

Май, ид, энэ Миний бие гэлээ.